

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч, Батсуурь Дуламсүрэн

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Сургуулийн орчин дахь хүүхдийн хөгжил, хамгаалал, орчны аюулгүй байдлыг хангах, багш, ажилтан, суралцагч, олон нийт, эцэг, эх асран хамгаалагчдын оролцоог дэмжих							
1	Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал төлөвлөх, хуваарилах зааврын төсөл боловсруулна.	Заавар	-	Зардал төлөвлөх, хуваарилах заавар боловсруулж, батлуулсан байна.	Боловсролын ерөнхий хуулиар “Боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт”-ийн зардлын бүрэлдэхүүнд сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын зардлыг багтаасан. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах заавар”-ын төслийг эцэслэн боловсруулж, тус яамны Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол шинэчлэн батлагдсантай холбоотой Боловсролын сайдын тушаалаар батлуулахаар Санхүүгийн хэлтэс ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд	10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хамгааллын зардлыг сургуулийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаа, эрсдэлийн үнэлгээнд суурилан төлөвлөх бөгөөд хүүхэд хамгааллын зардлын төсвийн 50-аас доошгүй хувийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд, 30 хүртэлх хувийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд, 20 хүртэлх хувийг шуурхай тусламжийн үйлчилгээнд зарцуулахаар тусгалаа. Энэхүү заавар батлагдсанаар сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй суралцагчийг илрүүлэх, эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, тэдний аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын холбогдох байгууллагад мэдээлэх, хүчирхийллийн хохирогч, холбогдогч суралцагчийг нөхөн сэргээх, чадавхжуулах, дахин хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй хүргэх боломж бүрдэнэ. Хавсралт: 1 файл		
2	Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаанд хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлэх цахим систем /after	Цахим систем	-	Цахим системээр дамжуулан хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлсэн	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулинд суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

	school/-ийг нэвтрүүлнэ.			байна.	ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байхаар заасан. 2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын 695 сургуульд 701,065 суралцагч суралцаж байгаагаас сургууль дээрх хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа, секц, дугуйланд давхардсан тоогоор 420,639 суралцагч буюу нийт суралцагчдын 60% нь хамрагдаж байна. Орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцагчийг хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаанд тэгш, хүртээмжтэй оролцуулах зорилгоор Equity Lab ТББ-тай хамтран “After school” цахим систем /аппликейшн/-ийг нэвтрүүлж дэлхийн иргэний боловсрол, мэргэжил сонголттой холбогдох 8 чиглэлийн 30 төрлийн хичээлээс сонгон сургалт, үйл ажиллагаанд хамрагдах боломжийг нэмэгдүүллээ. Ерөнхий боловсролын 441 сургууль цахим системд нэвтэрч, сургуулийн дэргэдэх 1,595 хөтөлбөр бүртгэгдсэн байна. Нийт 2,517 нийгмийн ажилтан, багш нэгдэж мэдээлэл солилцон ажиллахаас гадна нэвтрүүлэлтийн ажлын хүрээнд 56,212 суралцагч аппликейшн татаж, 15,310 суралцагч идэвхтэй хэрэглэгч болсон байна. Үнэгүй цахим сургалтын хамрагдалтыг 6,585-аар нэмэгдүүлсэн байна. Энэхүү “After	сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	----------------------------	--	--	--------	--	--	--

					school” цахим систем нь ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан хүүхдийн өсөлт хөгжлийн цогц платформ бөгөөд хичээлээс гадуурх цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, өсвөр насанд зориулсан менторшип, коучинг, сэтгэлзүйн зөвлөгөөг ганцаарчилж авах, нийгэм, хүрээлэн буй орчныхоо сайн сайхны төлөө хийж буй сайн дурын ажил, санаачлагаараа хийсэн эерэг үйлдлүүдээ бүртгэлжүүлж, урамшуулал бэлэг авах боломжтойгоороо ач холбогдолтой юм. Хавсралт: 2 файл		
3	. “Эрүүл-аюулгүй сургууль” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулна	Арга хэмжээний төлөвлөгөө	-	Сургуульд суурилсан эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдыг хамруулсан байна.	Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/80, А/384 дүгээр хамтарсан тушаалаар “Эрүүл-аюулгүй сургууль” арга хэмжээний төсөл, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, “Эрүүл-аюулгүй сургууль” арга хэмжээ, хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсрууллаа. Арга хэмжээ, хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг 2024 оны 10 дугаар сарын 11, 11 дүгээр сарын 24, 12 дугаар сарын 5-ны өдөр ажлын хэсэг, харьяа нэгж	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байгууллага, олон улсын байгууллагын төлөөллийн оролцоотой хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, сайжруулан эцэслэн боловсруулж, батлуулахаар нэгжийн дарга нарт эйбл системээр танилцуулж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/413, А/151 дүгээр хамтарсан тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах удирдамж"-ийг боловсруулж, батлуулав. Батлагдсан удирдамжийн дагуу эрт илрүүлгийн зохион байгуулалтыг хангаж, нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 200 эмч, нийгмийн ажилтан нарыг "Хараа шалгах үзлэгийн аргачлал"-ын сургалтад хамрууллаа. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангийн 2,666 суралцагч хамрагдсан бөгөөд зүрхний үзлэгт хамрагдсан 16,126 суралцагчийн 4.66% өөрчлөлттэй, шүдний үзлэгт хамрагдсан 19,926 суралцагчийн 78.4% нь өвчлөлттэй, нүдний үзлэгт хамрагдсан 13,883 суралцагчийн 22.5% өөрчлөлттэй гарч нарийн мэргэжлийн эмчид илгээх шаардлагатай байгааг гаргасан	
--	--	--	--	--	--	--

					байна. Хавсралт: 2 файл		
4	Сургуульд суурилсан эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдыг хамруулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана.	Боловсролын сайдын тушаал, хэрэгжилтийн дэмжлэг үзүүлсэн байдал	-	Сургуульд суурилсан эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдыг хамруулсан байна.	Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/413, А/151 дүгээр хамтарсан тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах удирдамж"-ийг боловсруулж, батлуулав. Эрт илрүүлгээр хүүхдийн эрсдэлт хүчин зүйлийг үнэлэх, эмнэл зүйн ерөнхий үзлэг хийх, хараа шалгах, нүдний үзлэг, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, зүрхний цахилгаан бичлэг хийх, дүгнэх, зүрхний хэт авиан шинжилгээ хийх, эмнэлзүйн дүгнэлт өгөх, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад оношийг тодруулахаар илгээх, хянах, эрүүл мэндийн боловсрол олгох цогц үйл ажиллагааг зохион байгуулна. Суралцагчдын нүдний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулахад шаардагдах харааны 50 багц хэрэглэгдэхүүнийг худалдан авахад шаардагдах зардал болох 60,314,250 төгрөгийг баталлаа. Түүнчлэн Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын 2024 оны А/372, А/67 дугаар хамтарсан	10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг эрт илрүүлгийн үзлэгийг нийслэлд 2024 оны 4 дүгээр улиралд, аймаг, суманд 2025 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулахаар ажиллаж байна. Батлагдсан удирдамжийн дагуу эрт илрүүлгийн зохион байгуулалтыг хангаж, нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 200 эмч, нийгмийн ажилтан нарыг "Хараа шалгах үзлэгийн аргачлал"-ын сургалтад хамрууллаа. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангийн 2666 суралцагч хамрагдсан бөгөөд зүрхний үзлэгт хамрагдсан 16,126 суралцагчийн 4.66% өөрчлөлттэй, шүдний үзлэгт хамрагдсан 19,926 суралцагчийн 78.4% нь өвчлөлттэй, нүдний үзлэгт хамрагдсан 13,883 суралцагчийн 22.5% өөрчлөлттэй гарч нарийн мэргэжлийн эмчид илгээх шаардлагатай байгааг гаргасан байна. Хавсралт: 3 файл		
5	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал зүйл)-ийг Улсын их хурлын	Хуулийн төсөл	Хуулийн төслийг Засгийн 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын их хуралд өргөн	-	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал зүйл)-ийг УИХ-ын хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, хуулийн төслийн 23 дугаар зүйл буюу "Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал" зүйлд санал өгч, сайжруулан хамтарч ажиллалаа.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

	хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлнэ		мэдүүлсэн		Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал зүйлд: сургалтын байгууллагын орчин, дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ; үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ; эцэг, эх, боловсролын байгууллагын талуудын үүрэг оролцоо; боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний үүрэг, оролцоо зэргийг тодорхойлж, нарийвчилсан зохицуулалтуудыг орууллаа. УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлж тайлбар мэдээлэл болон судалгааны үр дүнг нэгтгэн бэлтгэж, оролцлоо. Хүүхэд хамгааллын тухай хууль 2024 оны 9 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн бөгөөд хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудад танхим, цахим хосолсон сургалтыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгууллаа. Түүнчлэн хуулийг даган гарах “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам” “Нийтлэг шаардлага” “Боловсролын сургалтын байгууллагын орчны аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ын	төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--	-----------	--	---	---

					төслүүдийг боловсруулж байна Хавсралт: 4 файл		
6	“Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.	Төлөвлөгөө, батлагдсан тушаал	Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоол	Хэрэгжилтэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлсэн байна.	Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны А/27, А/25 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Олон нийтэд амны хөндийн өвчлөлөөс үүдэн учирч болох эрсдэлийн талаар таниулан, өвчлөлөөс сэргийлж, өдөр тутамд зөв дадал хэвшүүлэх зорилгоор “Шүд эрүүл бол бие эрүүл” аяныг үндэсний хэмжээнд хэрэгжүүллээ. Аяны хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 200 эмчийг танхимын, орон нутгийн 350 эмчийг цахимаар, нийт 550 эмчийг сургалтад хамрууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчдын 40.3 хувь нь буюу 351,644 суралцагч шүд, амны хөндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Эдгээр суралцагчдын 34.0 хувь нь буюу 122855 суралцагчийг эрүүл мэндийн байгууллагад холбон зуучилсан ба эдгээрийн 53.0 хувь нь буюу 65231 суралцагч шүдээ эрүүлжүүлж, амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд 140733 эцэг эх, асран хамгаалагчид дэмжиж ажилласан байна. Ерөнхий боловсролын нийт сургуулийн 48.6 хувь буюу 430 сургууль шүд угаах цагийн зохицуулалт хийсэн байна. Нийт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сургуулийн 17.1 хувь нь буюу 151 сургууль ариун цэврийн өрөөнөөс тусдаа 1548 шүд угаах цэг байгуулсан байна. Эдгээр сургуулиуд 1306 шүд угаах цэгийг өрөөнд, 240 шүд угаах цэгийг коридорт байгуулжээ. Бага ангийн суралцагчдын 17.7 хувь нь буюу 67253 суралцагч, дунд ахлах ангийн суралцагчдын 25.0 хувь буюу 106016 суралцагч сургуулийн орчинд шүдээ угааж хэвшсэн байна. Нийт сургуулийн 53.2 хувь нь буюу 470 сургууль шүд, амны хөндийн эрүүл мэндийг хамгаалахтай холбогдох сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдаж 66 сургууль 88.1 сая төгрөгийг сургуулийн нөөц, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэгтэйгээр зарцуулан зохион байгуулсан байна. Хавсралт: 4 файл		
7	ЕБС-д 6 настайдаа элсэх боломжгүй суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийг шийдвэрлэхэд баримтлах заавар боловсруулан батлуулна	Заавар, баталсан шийдвэр	-	-	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах зорилгоор "Ерөнхий боловсролын сургуульд хүүхдээ 6 настайд нь элсүүлэх боломжгүй эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтийг шийдвэрлэхэд баримтлах заавар"-ыг боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/251 дүгээр тушаалаар батлуулж, ерөнхий боловсролын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

					сургуулиудад хүргүүллээ. Энэхүү заавар нь зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ хуульд заасан насанд нь ерөнхий боловсролын сургуульд элсүүлэх боломжгүй эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтийг шийдвэрлэхэд сургуулийн хүүхэд хамгааллын багийг мэргэжлийн удирдамжаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. Уг зааварт: (i) сургуульд хүүхдээ 6 настайд нь элсүүлэх боломжгүй эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь сургуулийн захиргаанд хүсэлт гаргаж, түүнийг сургуулийн хүүхэд хамгааллын баг хэлэлцсэний дүнд, саналаа сургуулийн захиралд хүргүүлэх, (ii) гэр бүлийн орчинд хүүхдийн хөгжлийг бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн чадварыг дэмжихэд сургуулийн захиргаа, эцэг эх, асран хамгаалагч хамтран ажиллах талаар зохицуулалтыг тусгалаа. Сургуульд элсэх насыг нэг жилээр хойшлуулсан иргэний хүүхэд дараагийн хичээлийн жилд сургуульд элссэн эсэхийг мөшгөх судалгааг боловсролын газрын бага боловсрол болон хүүхдийн хөгжил, хамгааллын албан хаагч хийхээр үүрэг болголоо. Батлагдсан зааврын дагуу 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд элсэх хугацааг хойшлуулахыг хүссэн	гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	---------------------------------

					иргэн одоогийн байхгүй байна. Хавсралт: 1 файл		
8	“Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа-2023” судалгааны үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж боловсруулна.	Зөвлөмж	-	-	Хүүхдийг аливаа болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний аюулгүй байдлыг хангахад тэргүүлэх чиг үүрэг бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам хамтран “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа” үндэсний түүвэр судалгааг ерөнхий боловсролын сургуульд суурилан 13-17 насны суралцагчдын оролцоотой зохион байгуулж, үр дүнг үндэсний түвшинд тархаасан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 27,2 хувь буюу 4 суралцагч тутмын 1 нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургуулийн орчинд /сургуулийн коридор, анги, хичээлийн танхим, ариун цэврийн өрөө, биеийн тамирын заал гэх мэт хүүхэд олноор цуглардаг газар/ аюулгүй байдал алдагдсан, 38,8 хувь буюу 5 суралцагч тутмын 2 нь сургуульд ирж, буцахдаа ямар нэг тээврийн хэрэгслээр зорчдог, эмэгтэй суралцагчдын 64.0 хувь нь сургуульдаа ирж, буцахдаа гэрлэн дохионы ажиллагаагүй байдал, халтиргаатай зам, гэрэлтүүлэггүй гудамж, архи уудаг хүмүүс цуглардаг газар, нохой,	1-р сар, 2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					автомашины хөдөлгөөнөөс эмээх зэрэг саад бэрхшээлтэй тулгардаг, 3 суралцагч тутмын 1 нь сургууль дээрээ үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртөж байсан гэсэн үр дүн гарсан. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хүчирхийлэл, хорт зуршил, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах чиглэлээр зөвлөмжийг боловсруулж, БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 2/1017 тоот албан бичгээр Боловсролын газар, хэлтэст хүргүүлж, хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиглэлийг өгсөн. Хавсралт: 2 файл		
9	Дотуур байранд хүүхэд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зөвлөмж боловсруулж, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангана.	Зөвлөмж	-	Зөвлөмж боловсруулж, ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд хүүхэд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зөвлөмжийг боловсрууллаа. Хүүхэд өөрийн гэр бүлээсээ тусдаа тодорхой хугацаанд амьдрах нь гэрээ санах, шинэ амьдралын хэв маягт дасахгүй байх, олон хүүхэдтэй хамтдаа амьдрах зэрэг нь харилцааны бэрхшээлийг үүсгэх ялангуяа, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөх үүнээс улбаалан сургууль завсардах, гэр бүлтэйгээ дотно харилцах чадвар буурах, сэтгэл санааны дарамт гутралд автах зэрэг олон саар үр	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дагавар үүсэх эрсдэлтэй. Ялангуяа, малчин өрхийн хүүхдүүд жилийн 9 сард нь гэр бүлээсээ тусгаар амьдарч байгаа нь хүүхдийн өмнө боловсролын байгууллагын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлдэг. Иймээс дотуур байранд амьдрах хугацаанд хүүхдийн эрх, аюулгүй байдал нь санаатай болон санамсаргүй байдлаар алдагдах учиргүй хамгаалагдсан орчин байх ёстой тул уг зөвлөмжид хүүхдийг дотуур байрны өдөр тутамд давтагдах үйл ажиллагаанд дасах үйл явцад чиглүүлэх, харилцаа хандлагад дасах үйл явцад чиглүүлэх, багш, ажилтан, үе тэнгийнхэнтэй харилцах харилцааны дасан зохицолтыг дэмжих зэрэг агуулгыг тусгалаа. Зөвлөмжид сургуулийн удирдлага, анги удирдсан багш нар болон дотуур байрны багш нарын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн кейст тулгуурласан зөвлөмжийг орууллаа. Хавсралт: 1 файл		
10	Иргэний эрүүл мэндийн боловсролын дээшлүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг удирдлага,	Арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилт	ЗГ-ын 2023 оны 321 дүгээр тогтоол	Төлөвлөгөөнд 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан ЕБ-ын салбарит хамаарах үйл ажиллагааны хэрэгжилтийг удирдлага,	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/-г Эрүүл мэндийн сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/75, А/09, А/73,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	зохицуулалтаар хангана.			зохицуулалтаар хангаж, тайлагнасан байна.	A/34 дүгээр хамтарсан тушаалаар батлууллаа. Уг арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд боловсролын салбартай холбогдох 30 арга хэмжээний 10 нь гүйцэтгэхээр, 20 нь хамтран гүйцэтгэх арга хэмжээ байна. Төлөвлөгөөний 2.1-д заасан арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/80, А/384 дүгээр хамтарсан тушаалаар "Эрүүл-аюулгүй сургууль" арга хэмжээний төсөл, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, "Эрүүл-аюулгүй сургууль" арга хэмжээ, хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсрууллаа. Хавсралт: 2 файл	сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
11	ЕБС-ийн хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр боловсруулж, батлуулна	Батлагдсан тушаал	-	-	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/26 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөр"-ийг батлуулав. Уг үлгэрчилсэн хөтөлбөрт 8 тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, бага, дунд, ахлах ангид хичээлээс гадуурх, сургалт, үйл	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

					ажиллагаагаар эзэмшүүлэх ур чадварыг зааж, суралцагчийн сайн дурын үндсэн дээр тэдний сонирхол, хэрэгцээ, багшийн ур чадвар, хүний нөөц, орон нутгийн онцлог зэргийг харгалзан сургууль эсхүл нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагыг түшиглэн суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтийн оролцоотой зохион байгуулах зохицуулалтыг тусгалаа. Үүнд: 1) хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих, үүрэг оролцоог гэр бүлийн хүрээнд нэмэгдүүлэх, хэрэгжүүлэхэд хамтрах үйл ажиллагаа 2) эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх үйл ажиллагаа 3) бие бялдар, авьяас чадвар хөгжүүлэх үйл ажиллагаа 4) мэдээллийн технологийн ёс зүйтэй хэрэглээг дэмжих үйл ажиллагаа 5) суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаа 6) хувь хүний хөгжлийг дэмжих, дэлхийн иргэн байх ур чадвар эзэмшүүлэх 7) эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих 8) байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан. 2024-2025 оны хичээлийн жилд энэхүү үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу ерөнхий боловсролын 883	гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	---	--------------------------

					сургууль хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулж байна. Хавсралт: 1 файл		
12	“Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулна.	Шинэчилсэн журмын төсөл	-	Журмыг шинэчлэн боловсруулсан байна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан. Энэ хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ын төслийг эцэслэн боловсрууллаа. Журмын төсөлд хүүхдийн эсрэг хүчирхийлэл сургуулийн орчинд үйлдэгдсэн бол сургуулийн хүүхэд хамгааллын баг, гэр бүлийн орчинд үйлдэгдсэн бол сум, баг, хорооны хамтарсан багт холбон зуучилж, хамтран ажиллахаар тусгалаа. Энэхүү журмын хавсралтаар хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэх явцад сургуулийн нийгмийн ажилтны ажиллах маягтуудыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулж буй нөхцөл байдлын үнэлгээний маягттай уялдуулан боловсрууллаа. Журмын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ерөнхий газар болон Боловсролын газар, НБГ-ын Хүүхдийн эрхийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Японы хүүхдийг ивээх сан, Гүүд Нэйборс олон улсын байгууллага болон сургуулийн нийгмийн ажилтны төлөөллүүдийг оролцуулсан 3 удаагийн хэлэлцүүлэг, сургуулийн нийгмийн ажилтнуудын төлөөллийг оролцуулсан танхим, цахим хэлбэрээр 2 удаагийн хэлэлцүүлгүүдийг тус тус зохион байгуулж, санал, зөвлөмжийг тусган эцэслэлээ. Төслийг батлуулахаар нэгжийн дарга нарт танилцуулж байна. Хавсралт: 1 файл		
3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Монгол Улсын урт, дунд боино хугацааны бодлогын баримт бичгийн хнэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах.							
13	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь Иргэд, албан байгууллагаас хүссэн мэдээлэлд хариу өгсөн байдал	2023 оны байршсан мэдээлэл,	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг яамны цахим хуудасд байршуулсан байна. Иргэд, албан байгууллагаас хүссэн мэдээллийг хууль, журмын хүрээнд өгсөн байна.	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор боловсруулж буй “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ын төсөлд олон нийтийн санал авахаар 2024 оны 09 дүгээр сард тус яамны вэб сайтад байршууллаа. https://moe.gov.mn/post/154822 Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх сургалт, үйл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөр", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/251 дүгээр тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуульд хүүхдээ 6 настайд нь элсүүлэх боломжгүй эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтийг шийдвэрлэхэд баримтлах заавар", Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны А/27, А/25 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөөг тус тус нээлттэй байршууллаа. Бусад байгууллагаас тус яаманд хандсан шаардлагатай мэдээллийг гаргаж хүргүүлэв. Үүнд: 1. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулсан хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр төрийн байгууллагад хийсэн нээлттэй хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсэгт нийт 29 үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээлэл, тайланг бэлтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. Үүнд: Боловсролын статистик мэдээллүүд, хүний нөөц, орчин болон үйлчилгээний талаарх мэдээлэл, түүнчлэн 2019 оноос хойш батлагдсан эрх зүйн баримт бичиг, тайлангууд зэрэг болно. 2. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хүний эрхийн хорооны ажлын албанд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр боловсролын салбараас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр,	
--	--	--	--	--	---	--

					хууль тогтоомж, судалгаа, төсөл хөтөлбөрийн зарцуулалтын талаарх мэдээлэл бэлтгэн хүргүүлэв. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцож АТТ-ын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ур чадвараа ахиулна.	Хурал, семинарт оролцож АТТ-ын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ур чадвараа ахиулна.	-	Хурал, семинарт оролцож АТТ-ын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ур чадвараа ахиулсан байна.	1.БЯ, БСҮХ, БЕГ, БҮТ-өөс хамтран зохион байгуулсан “Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл арга зам-2024” эрдэм шинжилгээний хуралд оролцож, мэдлэг, ур чадвараа ахиуллаа. Уг хурлаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, боловсролын бодлогын хэрэгжилт, зарим үр дүн болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын аз жаргалтай	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					сайн сайхан байдал, сэтгэл хөдлөлийн чадамж зэрэг үндсэн илтгэлүүдийг хэлэлцүүлсэн 5 салбар хуралдаан болсон. 2.Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Жэй Си Ай Монгол төрийн бус байгууллагаас санаачлан зохион байгуулсан “Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд” чуулганд оролцож, өсвөр үеийнхний дунд тулгамдаж буй асуудлуудын талаар төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын танилцуулга, мэдээлэлтэй танилцаж, мэдлэг ур чадвараа ахиуллаа. 3.Гүүд Нэйборс олон улсын байгууллага, ГБХНХЯ болон Боловсролын яам хамтран “Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” Монгол-Солонгосын хамтарсан хурлыг 2024 оны 11 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэхүү хурлаар дамжуулан Монгол улс болон Солонгос улсын хүүхэд хамгааллын тогтолцоо, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга зам, туршлагыг бодлогын хүрээнд болон хэрэгжилтийн түвшинд хэлэлцлээ.		
--	--	--	--	--	--	--	--

					Хавсралт: 1 файл		
2	БШУЯ болон мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдана.	сургалт	-	БШУЯ болон мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдсан байна.	Төрийн албаны зөвлөл болон тус яамнаас зохион байгуулсан дараах сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа ахиуллаа. Үүнд: 1.“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь”; 2.Хүний эрх, хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа; 3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал; 4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг танилцуулах; 5.”Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-II” зохион байгуулах тухай 6.Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага”; 7.”Дижитал шилжилт, виртуал орчинд ажиллах” 8.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”; 9.Хорин нэгдүгээр зууны боловсрол Насан туршийн суралцахуй” сэдэвт сургалтуудад хамрагдаж, өөрийн ур чадвар, мэдлэг, ойлголтоо нэмэгдүүллээ.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч, Батсуурь Дуламсүрэн
/...../ Огноо: